

Mongolian language for foreigners – Week 15
Lecture №15

Сэдэв: Монголчуудын уламжлалт зан заншил
Topic: Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх
listening, speaking, reading, writing

Mongolian National University Arts And Culture
Professor, Basbish.S

Хичээлийн агуулга - Lecture content

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын уламжлалт зан заншил– Traditional customs of Mongolians:
infant's haircut custom
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест

1. Монгол төрийн их наадам нь _____ төрлөөс бүрддэг.
A. 1 Б. 2 В. 3 Г. 4
2. Улсын баяр наадмаар 256, 512, _____ бөх барилддаг.
A. 999 Б. 888 В. 1000 Г. 1024
3. Барилдах бөхийн нэрийг дуудахад _____ нь малгайг нь авч үлддэг.
 А. засуул Б. дасгалжуулагч В. шүүгч Г. Үзэгч
4. Барилдаанд унасан бөх _____ бүсийг тайлж, унаснаа мэдэгдэнэ.
A. өмднийхөө Б. даашинзныхаа В. дээлнийхээ Г. зодогныхоо
5. Улсын баяр наадмын тухай хуулинд зааснаар _____ дээш давсан бөхөд цол олгодог.
A. гурваас Б. таваас В. долоогоос Г. Есөөс

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

6. Улсын баяр наадмаар түрүүлсэн бөхөд _____ цол олгодог.
А. заан Б. гарди В. арслан Г. Аварга
7. Улсын баяр наадамд азарга, их нас, _____, хязаалан, шүдлэн, даага, гэсэн 6 насны ангилалд морьдыг уралдуулдаг.
А. гүү Б. морь В. унага Г. Соёолон
8. Уралдаанд түрүүлсэн морийг “_____” цолоор шагнадаг.
А. Онцгой морь Б. Хамгийн хурдан
 В. Түмэн эх Г. Нисдэг морь
9. Харваачид сур харваж, байгаа онох үед _____.
 А. Уухайлдаг Б. Дуулдаг В. Хашхирдаг Г. Алга ташдаг
10. Сурын харваанд шалгарсан хүмүүст Улсын цол, чимэг олгодог.
А. Мастер Б. Мэргэн В. Тэргүүн Г. Аварга

Хүүхдийн даахь үргээх ёс



Хүүхдийн даахь үргээх ерөөл [Photograph]. (2021, January 16). duuren.info.
<https://duuren.info/?p=3486>

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.

1. Хүүхдийн даахь гэж юу вэ?
2. Даахь үргээх ёс гэж юу вэ?
3. Хүүхдийн даахь үргээх ёслолд очиж байсан уу?
4. Хүүхдийн даахь үргээхэд ямар ямар ёс дагадаг вэ? Юуг цээрлэдэг вэ?

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning

1. Бага үд – before noon
2. Бэлгэ дэмбэрлийн үгс – words of good omen
3. Бэлэг – present, gift
4. Даахь – infant' hair before first cutting
5. Даахь авах – to cut infant's hair
6. Даахь үргээх – to cut infant's hair
7. Даахинд гар хүрэх – to cut infant's hair
8. Идээ засах – to put food on a bowl nicely for a ceremony or celebration
9. Идээ барих – to offer someone food respectfully
10. Ерөөх – to wish good fortune
11. Ерөөлийн үг – good wishes
12. Ёс – custom

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning

13. Ёслол – ceremony
14. Мянлаах – to bless
15. Найрын ахлагч – chief of the ceremony
16. Найрын ширээ – festive board
17. Нар жаргах - sun set
18. Нар зөв тойрон - clockwise
19. Сондгой - odd
20. Туг үс – lock of hair
21. Тусгайлан -specially
22. Тэгш - even
23. Цээрлэх – to avoid, to forbid
24. Хадаг – floss-silk scarf /ceremonial scarf/
25. Шанаа - temple

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын,
сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй*

Хүүхдийн даахь үргээх ёс

Монголчуудын эртний уламжлалт олон 1) _____ нэг нь "Хүүхдийн даахь үргээх" ёс юм. Хүүхэд эхээс төрөх үед толгойд нь ургасан байсан үсийг даахь гэж нэрлэдэг. Хүүхдийн даахийг анх авахдаа 2) _____, сайн өдрийг тусгайлан сонгож, авга, нагац ах, эгч нар, бусад хамаатан садан, хүндтэй зочдыг урьж, идээ засан ёслол хийдэг. Мөн хүүхдийн даахинд эхэлж гар хүрэх ивээл жилтэй хүнийг урина.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын,
сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй*

Хүүхдийн даахь үргээх ёс

Ингэхдээ эрэгтэй хүүхдийг 3) _____ настайд нь буюу гурав, тав, долоон настай байхад, эмэгтэй хүүхдийг 4) _____ настайд нь буюу хоёр, дөрөв, зургаан настай байхад даахийг нь авдаг. Хүүхдийн даахийг ёслол хийж авахаас өмнө хайчилж, тайрахыг цээрлэнэ.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Эрэгтэй хүүхэд



Хүүхдийн сэвлэг үргээх ёсон [Photograph]. (2016, March 15). www.mglnews.mn.
<http://www.mglnews.mn/content/read/58281.htm>

Эмэгтэй хүүхэд



Хүүхдийн даахь үргээх ёс [Photograph]. (2020, October 19). www.24tsag.mn.
<https://www.24tsag.mn/a/185755>

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын, сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй

Найр ёслолыг бага үдээс өмнө эхэлнэ. Найрын ширээнд заавал байх ёстой идээ бол 5) _____ буюу сүү, цагаан идээ. Даахь авах ёслолыг цагаалгаар эхэлнэ. Ирсэн бүх хүн энэ цагаалгаас амсах ёстой. Хүүхдийн даахинд гар хүрэхийн өмнө арц, хүж уугиулан хайчаа ариулна.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын, сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй

Хүүхдийн даахинд эхэлж гар хүрэх ивээл жилтэй хүн гэрийн баруун хойно суух бөгөөд найрын хамгийн 6) _____ хүн болдог. Даахийг нь авах хүүхдийг сайхан хувцаслаж, найрын ширээний тэргүүнд суулгана. Хүүхдийн эцэг, өвөө эсвэл найрын ахлагч “За одоо хүүгийнхээ даахийг үргээе” гэж хэлэн ёслолыг эхлүүлнэ.

Монголчуудын уламжлалт зан заншил Traditional customs of Mongolians- infant's haircut custom



Mongolian National Broadcaster. (2018, August 27).
Сэвлэг үргээх ёсон [Photograph]. www.mnb.mn.
<https://www.mnb.mn/i/149328>



Хүүхдийн даахь үргээх [Photograph]. (2017, February 26).
chuhal.mn.
<http://chuhal.mn/r/18720>

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын,
сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй*

Хүүхдийн даахийг авахдаа ивээл жилтэй хүн хүүхдэд эхлээд 7) _____ амсуулж, даахинд нь модон хутга хүргэн ёс үйлдэнэ. Дараа нь хадаг уясан хайчаар хүү бол баруун, охин бол зүүн шанаанаас туг үс хайчлан авч, хайчинд уясан хадганд боогоод, хүүхдэд сайн сайхныг бэлгэдсэн 8) _____ хэлнэ.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын,
сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй*

Үүний дараа нар зөв тойрон хүн бүр хүүхдэд сүү амсуулж, хэсэг үс хайчлан авч, хадганд боогоод, ерөөл, бэлгэ дэмбэрэлийн үг хэлж, бэлэг өгнө. Хүүхдийн даахинд гар хүрсэн хүмүүс хүүхдийн “толгойг мялааж” халзан цагаан хонь эсвэл хурга амладаг ёс бий.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 128)



Баяржаргал, Ч. (2018, August 20). Хүүхдийн даахь үргээх [Photograph]. tusgal.mn.

<http://www.tusgal.mn/khuukhdiin-daakhi-urgeekhed-urgukh-eruul-khamgiin-chukhal>

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын, сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй

Дараа нь гэрийн эзэгтэй зочдод идээ будаа барьж, хүмүүс дуу дуулж, бэлгэтэй үгсийг ярилцдаг. Мөн ёслол найранд ирсэн хүүхэд бүрт найрын хувь хүртээнэ. Ёслол дууссаны дараа хүүхдийн үлдсэн бүх үсийг нар жаргахаас 9) _____ авна. Нар жаргасны дараа хүүхдийн үсийг авдаггүй. Хүүхдийн даахийг хадагтай нь хадгалдаг.

Нэг жилд 3 үсний найранд орвол их сайн гэж үздэг заншил байна.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: цагаалга, ёс заншлын,
сүү, ерөөлийн үг, ивээл, архи/дарс, сондгой, өмнө, хүндтэй*

Цээрлэх зүйл: Хүүхдийн даахь үргээх найранд 10) _____, _____ хэрэглэдэггүй, таньж мэдэхгүй хүнээр үсэнд нь гар хүргүүлдэггүй.

Хүүхдэд хэлэх ерөөл:

Урт настай

Удаан жаргалтай

Аавдаа ачтай

Ээждээ тустай

Төр улсдаа зүтгэлтэй

Түмэн олныхоо манлай болж яваарай.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Энхрий бяцхан хүүгийнхээ

Онгон хонгор даахийг нь

Өдөж баясгаж авсны

Найр цэнгэл баяр бэлэг болгож

Намирсан их хадгаа дэлгээд

Нандин идээнийхээ дээжийг өргөөд

Найрын олны өмнө

Намайг бэлэг барь гэлээ хэмээн ерөөлч уг

найранд ерөөл хэлэх болсныхоо учрыг айлтгаад,

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Ган цагаан хайч
Гавшгай цагаан тонгоргийг бэлдээд
Алтан хайчны амыг нээж
Амь насыг нь даатгаж
Мөнгөн хайчны амыг нээж
Мөнх насыг нь даатгаж
Ган хошуутай
Алтан бариултай хайчаа
Гар мутар бүрийдээ
Дамжуулан үргээж
Гарсан төрсөн нас буяныг нь
Уртатгаж өргөөд гэх мэтээр хүүхдийн онгон даахь
үсэнд хамгийн анхлан хүндэтгэлтэйгээр хүрсэн учрыг
үзүүлсэн байдаг.

Ийнхүү хүүхдийн үсийг авахдаа эрэгтэй хүүхдэд тэвэг,
эмэгтэй хүүхдэд хоёр хөхөл хэлбэрийн үс үлдээдэг нь
хуучны ойлголт ёсоор төрийн хар хүн, гэрийн эх хүн
болохыг бэлгэдсэн заншил юм.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

1. Даахь гэж ямар үс вэ?
2. Хүүхдийн даахийг ямар өдөр авдаг вэ?
3. Эрэгтэй хүүхдийн даахийг хэдэн настай байхад нь авдаг вэ?
4. Эмэгтэй хүүхдийн даахийг хэдэн настай байхад нь авдаг вэ?
5. Хүүхдийн даахинд хамгийн эхэлж хэн гар хүрдэг вэ?

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

6. Хүүхдийн даахийг авахдаа ямар ёс, дараалал баримталдаг вэ?
7. Хүүхдийн даахь авах ёслолын хамгийн гол идээ юу вэ?
8. Хүмүүс хүүхдийн даахинд гар хүрсний дараа юу хэлж, юу өгдөг вэ?
9. Хүүхдийн үлдсэн үсийг хэзээ авдаг вэ?
10. Хүүхдийн даахь үргээх ёслолд юу юуг цээрлэдэг вэ?

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 4. Тохирох нөхцөлүүдийг ашиглан өгүүлбэрийг гүйцээнэ үү.

Exercise 4. Please use appropriate terms to complete the sentences accurately.

(-бал⁴, - тал⁴, - нгуут⁴, - нгаа⁴, - ж, - вч, - лгүй²)

1. Манай аав ээж хоёр намайг 5 нас хүр_____ даахийг минь аваагүй.
2. Хүүхдийн даахийг сайн өдөр ав_____ ирээдүйд сайн зүйл тохиолдоно гэж итгэдэг.
3. Хүүхдийн даахийг үргээ_____хамгийн бэлгэтэй сайн үгээр ерөөдөг.
4. Гэрт зочид ир_____ эхлээд цагаалга амсуулах ёстой.
5. Энэ өдөр олон зочин ирэх бол _____ танихгүй хүнээр хүүхдийн үс хөндүүлдэггүй.
6. Нар жаргахаас өмнө хүүхдийн үсгийг хөндсөний дараа ерөөл, бэлгэ дэмбэрэлийн үг хэл_____ бэлэг өгнө.

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 5. А. Дараах хэлц үгсийг тайлбартай нь тохируулна уу.

Exercise 5. A. Please match the following idioms with their corresponding explanations.

- | | |
|--------------|--|
| 1. Үс хөндөх | а. богино үсийг тайрч янзлах |
| 2. Үс засах | б. даахь авах |
| 3. Үс тайрах | в. үс гэзгээ самаар янзлах |
| 4. Үс хусах | г. үсэнд өнгө оруулах |
| 5. Үс самнах | д. урт үсийг тайрч богиносгох |
| 6. Үс сүлжих | е. Үс үлдээлгүй авах |
| 7. Үс будах | ё. Үсийг гурваас доошгүй хэсэг болгож, солбиулан багцлах |

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Дасгал 5. Б. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бичнэ үү.

Exercise 5. B. Please use the words provided above to complete the sentences accurately.

1. Үс хөндөх – Хүүхдийн үс хөндөх ёслолд оролцов.
2. Үс засах
3. Үс тайрах
4. Үс хусах
5. Үс самнах
6. Үс сүлжих
7. Үс будах

Гэрийн даалгавар 1 Homework 1

6. Хүүхдийн даахийг авахдаа ивээл жилтэй хүн хүүхдэд эхлээд _____ амсуулж, даахинд нь модон хутга хүргэн ёс үйлдэнэ.
- А. сүү Б. тараг В. айраг Г. цай
7. Хүүхдийн даахинд гар хүрсний дараа хүүхдэд сайн сайхныг бэлгэдсэн _____ хэлж, бэлэг өгнө.
- А. ерөөлийн үг Б. зүйр үг В. тууз Г. хадаг
8. Ёслол дууссаны дараа хүүхдийн үлдсэн бүх үсийг _____ өмнө авна.
- А. нар мандахаас Б. нар жаргахаас
В. сар мандахаас Г. сар жаргахаас
9. Хүүхдийн даахь үргээх найранд _____, _____ хэрэглэдэггүй.
- А. цагаан идээ Б. мах, өөх В. жимс, ногоо Г. архи, дарс
10. Хүүхдийн даахинд гар хүрсэн хүмүүс хүүхдийн “толгойг мялааж” халзан цагаан _____ эсвэл хурга амладаг ёс бий.
- А. морь Б. хонь В. ямаа Г. үхэр

Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- ***Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.***
Memorize vocabulary in the given topic
- ***Өөрийн орны хүүхэдтэй холбоотой зан заншлын талаар бичээрэй.***

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Хүүхдийн даахь үргээх ерөөл [Photograph]. (2021, January 16). duuren.info.

<https://duuren.info/?p=3486>

Хүүхдийн сэвлэг үргээх ёсон [Photograph]. (2016, March 15). www.mglnews.mn.

<http://www.mglnews.mn/content/read/58281.htm>

Хүүхдийн даахь үргээх ёс [Photograph]. (2020, October 19). www.24tsag.mn.

<https://www.24tsag.mn/a/185755>

Mongolian National Broadcaster. (2018, August 27). Сэвлэг үргээх ёсон [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/149328>

Хүүхдийн даахь үргээх [Photograph]. (2017, February 26). chuhal.mn.

<http://chuhal.mn/r/18720>

Баяржаргал, Ч. (2018, August 20). Хүүхдийн даахь үргээх [Photograph]. tusgal.mn.


<http://www.tusgal.mn/khuukhdiin-daakhi-urgeekhed-urgukh-eruul-khamgiin-chukhal>

Монголчуудын уламжлалт зан заншил
Traditional customs of Mongolians- infant's haircut custom

Анхаарал хандуулсанд
баярлалаа.
Дараагийн хичээл хүртэл
баяртай!



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>